

Монголын Таеквондогийн холбооны тэмцээн явуулах журам

/тулаан/

Монгол улсад зохион байгуулагдаж буй бүхий л таеквондогийн тэмцээн Дэлхийн Таеквондогийн холбооны дүрмийн дагуу явагдана.

1) Тэмцээний аргачлал: Тэмцээнийг хасагдах системээр явуулна.

2) Тэмцээний ерөнхий шаардлага:

- I. Тэмцээнийг Дэлхийн Таеквондогийн холбооны дүрмийн дагуу явуулна.
- II. Тэмцээнд оролцогч тамирчин бүр Дэлхийн таеквондогийн холбооноос албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн цээжний хамгаалалт, хамгаалалтын малгай заавал өмсөнө. Тэмцээнд хэрэглэх тамирчдын цахим малгай, цээжний хамгаалалтыг тэмцээнийг зохион байгуулагчдын зүгээс хариуцна. Цахим бус энгийн цээжний хамгаалалт, малгайг тэмцээнд оролцогч баг, тамирчид өөрсдөө хариуцна.
- III. Тулааны төрөлд зөвхөн тухайн жилд 8 буюу түүнээс дээш насны тамирчин оролцох эрхтэй.
- IV. 12 хүртэлх насны тамирчдын тулаанд цахим бус энгийн хамгаалалт хэрэгсэл ашиглана.
- V. Өнгийн бүсний ангилалын тулаанд цахим бус энгийн хугу, малгай ашиглана.
- VI. Тэмцээнд оролцогч тамирчин нь таеквондогийн спортоор хамгийн багадаа **зургаан сараас** доошгүй хугацаанд хичээллэсэн байх ёстой.
- VII. Тамирчин нь тухайн жилийн Монголын Таеквондогийн холбооны лиценз авч бүртгүүлсэн байна.

3) Тамирчинд тавигдах шаардлага:

- I. Тэмцээнд оролцогч тамирчин бүр Дэлхийн таеквондогийн холбооноос албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн Таеквондогийн өмсгөл буюу тобок заавал өмсөнө.
- II. Тамирчид болон клуб өөрсдөө хөлийн оймс, гарын бээлий, шүд, шилбэ, шуу, эмзэг эрхтэний хамгаалалтуудыг хариуцах болно. Оролцогч бүх тамирчид дээр дурдсан хамгаалах хэрэглэлүүдийг заавал хэрэглэнэ.
Жич: Шүдний хамгаалалтын хувьд өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэйгээс бусад өнгөтэй шүдний хамгаалалт зүүхийг хориглоно.
- III. Таеквондогийн спортоор хичээллэгч нь хүндлэх, хүндэтгэх ёсыг баримталж шүүгч болон тэмцээн зохион байгуулагчдын аливаа шаардлагыг үл маргах зарчмаар хүндэтгэлтэй хандаж биелүүлэх үүрэг хүлээнэ.

4) Тэмцээний цаг:

- I. /Элит ангилал/: Тус бүр 1 минут 30 секунд үргэлжилэх 3 үе тулалдана. Үе хооронд 1 минут завсарлана.
- II. Өнгийн бүсний ангилалын тамирчид тус бүр 1 минут үргэлжлэх 3 үе тулалдана.
- III. 3 дугаар үед оноо тэнцсэн тохиолдолд нэмэлт 4 дүгээр үед Алтан онооны дүрэм хэрэгжих буюу хэн түрүүлж 2 буюу түүнээс дээш оноо авсан талд ялалтыг өгнө. Энэхүү 4 дүгээр үе нь 1 минут үргэлжлэнэ.
- IV. Насанд хүрэгчийн ангилалд /17 наснаас дээш/ шигшээ тоглолт тус бүр 2 минут үргэлжлэх 3 үе тулалдана.

5) Тэмцээний жин

Монголд зохион байгуулагдах бүхий л тэмцээн дэлхийн холбооны дүрмийн дагуу насны ангилал бүр дээр эрэгтэй, эмэгтэй дараах жингүүдээр зохион байгуулна. Нас нь сараар бус оноор тооцох зарчмыг баримтлана.

Бага нас (8-9нас)

Эр		Эм	
- 24 кг	24 кг хүртэлх	- 23 кг	23 кг хүртэлх
- 26 кг	24 кг жингээс 26 кг жингийн хооронд	- 25 кг	23 кг жингээс 25 кг жингийн хооронд
- 28 кг	26 кг жингээс 28 кг жингийн хооронд	- 27 кг	25 кг жингээс 27 кг жингийн хооронд
- 30 кг	28 кг жингээс 30 кг жингийн хооронд	- 29 кг	27 кг жингээс 29 кг жингийн хооронд
+ 30 кг	30 кг жингээс дээш жинтэй тамирчид	+29 кг	29 кг жингээс дээш жинтэй тамирчид

Бага нас (10-11нас)

Эр		Эм	
- 26 кг	26 кг хүртэлх	- 25 кг	25 кг хүртэлх
- 29 кг	26 кг жингээс 29 кг жингийн хооронд	- 28 кг	25 кг жингээс 28 кг жингийн хооронд
- 32 кг	29 кг жингээс 32 кг жингийн хооронд	- 31 кг	28 кг жингээс 31 кг жингийн хооронд
- 35 кг	32 кг жингээс 35 кг жингийн хооронд	- 34 кг	31 кг жингээс 34 кг жингийн хооронд
- 38 кг	35 кг жингээс 38 кг жингийн хооронд	- 37 кг	34 кг жингээс 37 кг жингийн хооронд
+ 38 кг	38 кг жингээс дээш жинтэй тамирчид	+37 кг	37 кг жингээс дээш жинтэй тамирчид

Өсвөр нас (12-14 нас):

Эр		Эм	
- 33 кг	33 кг хүртэлх	- 29 кг	29 кг хүртэлх
- 37 кг	33 кг жингээс 37 кг жингийн хооронд	- 33 кг	29 кг жингээс 33 кг жингийн хооронд
- 41 кг	37 кг жингээс 41 кг жингийн хооронд	- 37 кг	33 кг жингээс 37 кг жингийн хооронд
- 45 кг	41 кг жингээс 45 кг жингийн хооронд	- 41 кг	37 кг жингээс 41 кг жингийн хооронд

- 49 кг	45 кг жингээс 49 кг жингийн хооронд	- 44 кг	41 кг жингээс 44 кг жингийн хооронд
- 53 кг	49 кг жингээс 53 кг жингийн хооронд	- 47 кг	44 кг жингээс 47 кг жингийн хооронд
- 57 кг	53 кг жингээс 57 кг жингийн хооронд	- 51 кг	47 кг жингээс 51 кг жингийн хооронд
- 61 кг	57 кг жингээс 61 кг жингийн хооронд	- 55 кг	51 кг жингээс 55 кг жингийн хооронд
- 65 кг	61 кг жингээс 65 кг жингийн хооронд	- 59 кг	55 кг жингээс 59 кг жингийн хооронд
+ 65 кг	65 кг жингээс дээш жинтэй тамирчид	+59 кг	59 кг жингээс дээш жинтэй тамирчид

Залуучууд (15-17 нас):

Эр		Эм	
- 45kg	45kg хүртэлх	- 42kg	42kg хүртэлх
- 48kg	45kg жингээс 48kg жингийн хооронд	- 44kg	42kg жингээс 44kg жингийн хооронд
- 51kg	48kg жингээс 51kg жингийн хооронд	- 46kg	44kg жингээс 46kg жингийн хооронд
- 55kg	51kg жингээс 55kg жингийн хооронд	- 49kg	46kg жингээс 49kg жингийн хооронд
- 59kg	55kg жингээс 59kg жингийн хооронд	- 52kg	49kg жингээс 52kg жингийн хооронд
- 63kg	59kg жингээс 63kg жингийн хооронд	- 55kg	52kg жингээс 55kg жингийн хооронд
- 68kg	63kg жингээс 68kg жингийн хооронд	- 59kg	55kg жингээс 59kg жингийн хооронд
- 73kg	68kg жингээс 73kg жингийн хооронд	- 63kg	59kg жингээс 63kg жингийн хооронд
- 78kg	73kg жингээс 78kg жингийн хооронд	- 68kg	63kg жингээс 68kg жингийн хооронд
+ 78kg	78kg жингээс дээш жинтэй тамирчид	+ 68kg	68kg жингээс дээш жинтэй тамирчид

Залуучуудын Олимпын жин (15-17 нас) :

Эр		Эм	
- 48kg	48kg хүртэлх	- 44kg	44kg хүртэлх
- 55kg	48kg жингээс 55kg жингийн хооронд	- 49kg	44kg жингээс 49kg жингийн хооронд
- 63kg	55kg жингээс 63kg жингийн хооронд	- 55kg	49kg жингээс 55kg жингийн хооронд
- 73kg	63kg жингээс 73kg жингийн хооронд	- 63kg	55kg жингээс 63kg жингийн хооронд
+ 73kg	73kg жингээс дээш жинтэй тамирчид	+ 63kg	63kg жингээс дээш жинтэй тамирчид

Насанд хүрэгч (17 наснаас дээш)

Эр		Эм	
- 54kg	54kg хүртэлх	- 46kg	46kg хүртэлх
- 58kg	54kg жингээс 58kg жингийн хооронд	- 49kg	46kg жингээс 49kg жингийн хооронд
- 63kg	58kg жингээс 63kg жингийн хооронд	- 53kg	49kg жингээс 53kg жингийн хооронд
- 68kg	63kg жингээс 68kg жингийн хооронд	- 57kg	53kg жингээс 57kg жингийн хооронд
- 74kg	68kg жингээс 74kg жингийн хооронд	- 62kg	57kg жингээс 62kg жингийн хооронд
- 80kg	74kg жингээс 80kg жингийн хооронд	- 67kg	62kg жингээс 67kg жингийн хооронд
- 87kg	80kg жингээс 87kg жингийн хооронд	- 73kg	67kg жингээс 73kg жингийн хооронд
+ 87kg	87kg жингээс дээш жинтэй тамирчид	+ 73kg	73kg жингээс дээш жинтэй тамирчид

Олимпын их наадмын жин

Эр		Эм	
- 58kg	58kg хүртэлх	- 49kg	49kg хүртэлх
- 68kg	58kg жингээс 68kg жингийн хооронд	- 57kg	49kg жингээс 57kg жингийн хооронд
- 80kg	68kg жингээс 80kg жингийн хооронд	- 67kg	57kg жингээс 67kg жингийн хооронд
+ 80kg	80kg жингээс дээш жинтэй тамирчид	+ 67kg	67kg жингээс дээш жинтэй тамирчид


Тайлбар: Жин тус бүрт заасан жиндээ багтаж орох хэрэгтэй ба заасан жингээс 100гр илүү жинтээ байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох шаардлагатай.

Дараах шаардлагыг бүрэн хангасан клуб, тамирчид жингээ үзүүлэх эрхтэй болно. Үүнд:

- Тэмцээний өмнө заасан хугацаанд бүртгэлээ хийлгэж мандатаа авсан байх ёстой. /мандатыг авч ирэх/
- Монголын таеквондогийн холбооноос олгосон тухайн оны хүчинтэй лицензтэй байх. /Лицензийг авч ирэх/
- Тамирчдын жинг үзүүлэхдээ клуб тус бүр өөрийн клубын тамирчдын урьдчилсан мэдүүлгийг хэвлэмэлээр авч ирэх.
- Бага насны тамирчдын жинг олон кг-р хасахгүй байх.
- Жинг үзэх өдөр тамирчин бүрийн жинг дээд тал нь хоёр удаа үзэж баталгаажуулна.

6) Тэмцээний дэвжээ

Тэмцээнийг дэлхийн стандартад нийцсэн дэвжээн дээр явуулна.



7) Оноо олгох зарчим

7.1 Хөх болон улаан өнгөөр ялгасан цээжний хамгаалалт болон малгайд оновчтой өшиглөлт цээжний хамгаалалтад оновчтой цохьсон гарын оноог өгнө.

7.2 Тухайн жин, насны ангилал, хүйснээс хамаарч цохилтын хүч харилцан адилгүй байх тул тухайн тамирчидад тохирохуйц цохилтын хүчий ялгамжтайгаар оноо олгогдоно.

7.3 Дараах онооны систем үйлчлэнэ.

7.3.3. **Нэг оноо:** Цээжний хамгаалалтад оновчтой цохьсоныг булангийн шүүгчдийн олонхийн саналаар

7.3.4 **Хоёр оноо:** Цээжний хамгаалалтад оновчтой бөгөөд хүчний үйлчлэл нь таарсан өшиглөлт тус бүрт

7.3.5 **Дөрвөн оноо:** Цээжний хамгаалалтад оновчтой бөгөөд хүчний үйлчлэл нь таарсан эргэлттэй өшиглөлт тус бүрт

7.3.6 **Гурав оноо:** Толгойны хамгаалалтад оновчтой бөгөөд хүчний үйлчлэл нь таарсан өшиглөлт тус бүрт

7.3.7 **Таван оноо:** Толгойны хамгаалалтад оновчтой бөгөөд хүчний үйлчлэл нь таарсан эргэлттэй өшиглөлт тус бүрт

7.3.8 **Нэг оноо:** Өрсөлдөгч тамирчин торгууль авсан тохиолдолд нэмэлт нэг оноог авна.

7.4 Торгуулийн систем.

Торгуулийг дараах тохиолдолуудад өгнө.

7.4.1. Дэвжээнээс гарсан тохиолдолд

7.4.2. Унасан тохиолдолд

7.4.3. Идэвхигүй байдал гаргасан тохиолдолд

7.4.4. Зуурсан болон түлхсэн тохиолдолд

7.4.5. Бүсэлхийнээс доош өшиглөсөн болон блок тавьсан тохиолдолд

7.4.6. Хөлийг 3 секундээс дээш хугацаанд өргөн өшиглөлт хийгээгүй тохиолдолд

7.4.7. Шүүгчийн зогс командын дараа өшиглөлт хийсэн тохиолдолд

7.4.8. Толгойн хэсэгт гараар цохьсон тохиолдолд

7.4.9. Өвдөглөсөн тохиолдолд

7.4.10. Өрсөлдөгч тамирчин унасан үед довтолгоо хийсэн тохиолдолд

7.4.11. Таеквондогийн бус техник гүйцэтгэсэн тохиолдолд

7.4.12. Дасгалжуулагчаас хамаарч тамирчинг торгон тохиолдолууд

- Шүүгчдийн шийдвэрийг үл биелүүлсэн тохиолдолд
- Зүй бус үг хэллэг, үйлдэл гаргасан тохиолдолд
- Тамирчны ард дасгалжуулагчаас өөр хүн суусан тохиолдолд

7.4.13 Тухайн тамирчны торгуулийн хэмжээ нэг тоглолтод 10 хүрсэн тохиолдолд шууд ялагдал хүлээнэ.